



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

┌
Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой
халдварыг илрүүлэх, тандах, хариу арга
хэмжээг авч хэрэгжүүлэх тухай
└


Эрүүл мэндийн сайдын “Журам батлах тухай” 2014 оны 186 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт, “Заавар батлах тухай” 187 дугаар тушаалын 11 дүгээр хавсралт, “Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой зарим халдварыг илрүүлэх, тандалтын заавар батлах тухай” 2019 оны А/74 дүгээр тушаалыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн төвийн тасаг нэгжүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг илрүүлэх тандах үйл ажиллагааны заавар журмуудыг мөрдүүлж удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Т.Гэрэлсүрэн/-д даалгасугай.
2. Мэс заслын дараах шархны халдварын тандалтыг ЭМС-ын 2019 оны А/74 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан зааврын дагуу хийж тандах хуудас 4-ийг хөтөлж халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдлуудыг тухай бүр нь мэдээлж байхыг мэс заслын эмч /Цолмон, Габит/ нарт үүрэг болгосугай.
3. Хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгчид даалгах нь:
 - 3.1. Хэвтэн эмчлүүлэгчид болон үйлчлүүлэгчдийн дунд шээлгүүртэй холбоотой шээсний замын халдвар илрүүлэх, зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушигины хатгаа илрүүлэх, судасны гуурстай холбоотой халдварын тандалтыг хүлээн авах яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, гемодиализ, дотор мэдрэлийн тасгуудад тус тусд нь хийлгэж тандалтын хуудсуудыг хөтлүүлэх
 - 3.2. Хэвтэн эмчлүүлэгчдийн дунд шээлгүүртэй холбоотой шээсний замын халдвар илрүүлэх, зохиомол амьсгалын аппараттай холбоотой уушигины хатгаа илрүүлэх, судасны гуурстай холбоотой халдварын тандалтыг ЭМС-ын 2019 оны А/74 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан зааврын дагуу хийж тандах хуудас 5,6 болон, ЭМС-ын оны 186 тоот тушаалын 4-р хавсралтын хүснэгт-6 –г тус тус хөтөлж халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдлуудыг тухай бүр нь мэдээлж байх

30170 70 0200

- 3.3. Шээлгүүр тавих, судасны гуурс тавих иж бүрдлүүдийг холбогдох заавар журмын дагуу урьдчилан бэлтгэж үжилгүйжүүлэх техникийг баримтлан тавьж байх
- 3.4. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар илрүүлэх тандалтын үйл ажиллагаанд тасгийн халдварын сэргийлэлт хяналтын багийн гишүүд, ахлах сувилагч нар өдөр тутмын байнгын хяналтыг тавьж үйл ажиллагааг тогтмолжуулж ажиллах
4. Тархвар судлаач эмч /С.Өлзийжаргал/-д үүрэг болгох нь:
- 4.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг илрүүлэх тандах үйл ажиллагааны талаар эмч сувилагч нарт сургалт хийж тасаг нэгжүүдэд хийгдэж буй тандалтын явцад хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах
- 4.2. ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдол халдварын шалтгааныг тогтоох, эрсдэлт хүчин зүйлсийг арилгах, халдвар тархалтыг бууруулахад чиглэсэн хариу арга хэмжээг халдварын сэргийлэлт хяналтын албаны гишүүдтэй хамтран хэрэгжүүлж ажиллах
- 4.3. ЭТҮХХ-ын сэжигтэй болон батлагдсан тохиолдлын мэдээг сар бүр нэгтгэн Нийслэлийн эрүүл мэндийн газар, ХӨСҮТ-ийн тандалтын нэгжүүдэд мэдээлж байх
5. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын албаны дарга /Б.Оюунмэд/-д даалгасугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ